



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Уланбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatassembly@parliament.mn
Http://www.parliament.mn

2024.09.25 № 16

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН
САЙД Ч.НОМИН ТАНАА

Соёлын төв, ариун цэврийн байгууламж,
авто зогсоол бүхий отоглох цэгийг шинээр
байгуулах талаар

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" мөн хэсгийн 6.4.3 дахь заалтад "иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой хөтөлбөр, арга хэмжээг тэдгээрээр гүйцэтгүүлэх чиглэл баримтлах", 6.5.5 дахь заалтад "хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх" гэсэн зарчмуудыг мөрдөхөөр заасан.

Мөн төсвийн тодотголыг тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтад "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх", 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт "Засгийн газар дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ:", мөн хэсгийн 34.1.1 дэх заалтад "Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүй байх нөхцөл байдал үүссэн;", 34.1.2 дахь заалтад "урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувиар нэмэгдэх;", 34.1.3 дахь заалтад "энэ хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах;", 34.1.4 дэх заалтад "төсвийн ерөнхийлен захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх.", 34.1.5 дахь заалтад "хууль болон гэрээнд зааснаар Засгийн газрын өрийн баталгааны төлбөрийн үүргийг гүйцэтгэхэд Засгийн газрын өрийн баталгааны сангийн хөрөнгө хүрэлцэхгүй болсон" гэх нөхцөлд хийхийг тус тус заажээ.

Харамсалтай нь дээрх хуулийн заалтуудын дагуу төсвийн тодотгол хийх нөхцөл, шаардлагыг хангаагүй, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэгдээгүй, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг хангаагүй байж болзошгүй, ач холбогдлын эрэмбэ, дараалалд олон нийтийн саналыг харгалзсан эсэх нь тодорхойгүй, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх боломжтой төсөл, арга хэмжээ болох 5,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын ев

бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэгийг шинээр байгуулахаар 2024 оны төсвийн тодотгол, 2025 оны төсвийн төсөлд тусгажээ. Нийт төсвийн 65 орчим хувь буюу 3.7 тэрбумыг нь үлдсэн 4 сарын хугацаанд буюу 2024 онд санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Дашрамд, 2024 оны төсвийн тодотголд шинээр 74,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий Соёлын төвүүдийг барихаар тусгаснаас үлдсэн 4 сарын хугацаанд буюу 2024 онд 22.5 тэрбумын санхүүжилт хийхээр төсөвлөснийг бас дурдья.

Иймд Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6.1.1-дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна.

Үүнд:

1.Хавсралт 1-т заасан "Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг"-ийг барих хэрэгцээ, шаардлага болон улсын төсвөөс санхүүжүүлэх шалтгаан, үндэслэлийн талаарх дэлгэрэнгүй тайлбар;

2.Уг цэгийн үйл ажиллагаа, бүтэц, орон тоо, төсвийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

3.Уг цэгийн ашиглалт, менежмент, үйл ажиллагааны орлого, зардал, ашгийн талаарх мэдээлэл;

4.Монгол Улсын бүх сум, суурин газрууд дахь нийт соёлын төвийн барилгуудын тоо, насхилт, үйл ажиллагааны орлого, зарлага, үр ашиг, үр дүнгийн талаарх мэдээллийг соёлын төв тус бүрээр;


5.Хавсралт 2-т заасан сумдад шинээр барихаар төлөвлөсөн соёлын төвүүдийг 2023 оны төсөвт тусгаагүйн шалтгааны талаарх тайлбар.

6.Хавсралт 2-т заасан сумдад соёлын төвүүд шинээр барихаар 2024 оны төсвийн тодотголд тусгасан шалтгаан, хэрэгцээ, шаардлага, үндэслэлийн талаарх тайлбар;

Асуултын хариут Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, мөн зүйлийн 11.4 дэх хэсэгт заасны дагуу холбогдох Байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэх болно.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ж.БАЯРМАА

20240032

Хавсралт 1

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төслийн код	Эхпэх	Дуусах	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн	2025 оны төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
XVI.1.1.6	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоплох цэг /УВС, Малчин, Хяргас сум, Хяргас нуур/	УТ2401300906	2024	2026		1,500.0	500.0	-	-
XVI.1.1.7	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоплох цэг /УВС, Тариалан сум, Увс нуур/	УТ2401300883	2024	2025		1,874.1	874.1	-	-
XVI.1.1.8	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоплох цэг /Улсын хэмжээнд/	УТ2401300886	2024	2024		2,325.0	2,325.0	-	-
Нийт				-	5,699.1	3,699.1	-	-	-

Хавсралт 2

Хуулийн дугаар	Төсөл, ага хэмжээний нар, хүчин чадал, байршил	Төслийн код	Эхлэх дуусах	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн	2025 оны төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
XVI.2.1.11	Соёлын төвийн барилга, 240 судал /Дундговь, Цагаандалгэр сум/	УТ2003400753	2019	2025	1,230.0	2,288.2	100.0	2,288.3
XVI.2.1.14	Соёлын төвийн барилга, 300 судал /Баян-Өлгий, Улаанхус сум/	УТ1903400004	2019	2025	1,100.0	2,459.9	100.0	-
XVI.2.1.20	Соёлын төвийн барилга, 200 судал /Хөвсгөл, Ренчинпүхмбэз сум/	УТ2003400749	2020	2025	1,400.0	4,600.0	1,436.2	4,600.0
XVI.2.1.21	Соёлын төвийн барилга, 240 судал /Баянхонгор, Олзийт сум/	УТ2003400739	2020	2025	1,300.0	2,284.2	20.4	2,284.2
XVI.2.1.30	Соёлын төвийн барилга, 300 судал /Сүхбаатар, Баяндэлгэр сум/	УТ2003400783	2021	2025	1,988.5	2,285.8	40.0	2,285.9
XVI.2.1.36	Соёлын төвийн барилга, 400 судал /Өвөрхангай, Хужирт сум/	УТ2103400484	2022	2025	2,500.0	3,950.3	1,571.9	3,950.4
XVI.2.1.42	Соёлын төвийн барилга /Архангай,Өгийнuur сум/	УТ2403401084	2024	2026		4,231.9	1,269.6	4,231.9

XVI.2.1.43	Соёлын төвийн барилга /Дорноговь, Дэлгэрэх сум/	УТ2403400618	2024	2026	4,191.9	1,257.6	4,191.9	1,467.2
XVI.2.1.44	Соёлын төвийн барилга /Дорноговь, Эрдэнэ сум/	УТ2403401111	2024	2026	3,456.9	1,037.1	3,221.5	974.5
XVI.2.1.45	Соёлын төвийн барилга /Салэнгэ, Зүүнбурэн сум/	УТ2403401094	2024	2026	3,886.0	1,165.8	-	-
XVI.2.1.46	Соёлын төвийн барилга /Сүхбаатар, Онгон сум, 5 дугаар баг/	УТ2403400088	2024	2026	4,184.0	1,255.2	4,184.0	2,928.8
XVI.2.1.47	Соёлын төвийн барилга /Увс, Малчин сум/	УТ2403401099	2024	2026	3,750.0	755.0	3,737.8	1,485.3
XVI.2.1.48	Соёлын төвийн барилга, 200 судал /Завхан, Дервэлжин сум/	УТ2403400682	2024	2026	4,512.5	1,065.7	4,490.0	1,701.0
XVI.2.1.49	Соёлын төвийн барилга, 200 судал /Завхан, Отгон сум/	УТ2403401092	2024	2026	4,512.5	1,065.7	4,444.3	1,655.3
XVI.2.1.50	Соёлын төвийн барилга, 200 судал /Завхан, Сонгино сум/	УТ2403400551	2024	2026	4,968.0	600.0	4,920.8	2,136.8
XVI.2.1.51	Соёлын төвийн барилга, 230 судал /Завхан, Ургамал сум/	УТ2403401130	2024	2026	3,628.0	500.0	3,628.0	1,564.0
XVI.2.1.52	Соёлын төвийн барилга, 240 судал /Булган, Бүрэхангай сум/	УТ2403400348	2024	2026	3,831.9	1,149.6	3,831.9	1,341.2
XVI.2.1.53	Соёлын төвийн барилга, 250 судал	УТ2403401091	2024	2025	2,868.9	1,434.5	2,816.9	1,382.5

	/Дундговь, Баянжаралтан сум/						
XVI.2.1.54	Соёлын төвийн барилга, 250 судал /Дундговь, Дэлгэрхангай сум/	УТ2403400532	2024	2025	2,868.9	1,434.5	2,858.9 1,424.4
XVI.2.1.55	Соёлын төвийн барилга, 250 судал /Хөвсгөл, Ханх сум/	УТ2403401119	2024	2026	4,135.1	1,306.6	4,135.1 1,414.3
XVI.2.1.56	Соёлын төвийн барилга, 250 судал /Хөвсгөл, Эрдэнэбулагн сум/	УТ2403401132	2024	2026	3,810.0	1,000.0	3,804.3 1,399.3
XVI.2.1.57	Соёлын төвийн барилга, 250 судал /Өвөрхангай, Тэрэг сум, 1 дугаар баг/	УТ2403401112	2024	2026	2,712.0	813.6	2,702.6 939.8
XVI.2.1.58	Соёлын төвийн барилга, 400 судал /Салэнгэ, Ерөө сум/	УТ2403401095	2024	2025	3,885.9	1,943.0	3,847.6 1,904.7
XVI.2.1.59	Соёлын төвийн барилга, 400 судал /Сэлэнгэ, Худэр сум/	УТ2403401096	2024	2025	3,627.2	1,813.6	3,576.6 1,763.0
XVI.2.1.60	Соёлын төвийн барилга, 400 судал /Хөвсгөл, Галт сум, 5 дугаар баг/	УТ2403401120	2024	2026	5,650.0	1,695.0	5,650.0 1,977.5
					9,518.5	92,580.0	25,830.1 34,646.0
					Нийт		